



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 06 өдөр

Дугаар А/561

Хэрлэн сум

“Эрчүүдийн эрүүл мэнд” хөтөлбөрийн  
хүрээнд хөрөнгө зарцуулах тухай


Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны хоёрдугаар хуралдааны “Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 6 дугаар тогтоол, 2023 оны арваннайм дугаар хуралдааны “Аймгийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” 2 дугаар тогтоолын 06 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “ Эрчүүдийн эрүүл мэнд” арга хэмжээний хүрээнд төрийн болон төрийн бус байгууллагуудын эрэгтэй албан хаагчдыг “Эрчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэнд” сэдэвт сургалт, үзлэг, шинжилгээнд хамруулахад 6,120,000 (зургаан сая нэг зуун хорин мянга) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.


2.Шаардагдах хөрөнгийн тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2023  
оны 11 дугаар сарын 06-ны  
дугаар захирамжийн хавсралт

ЭРЧҮҮДИЙН ЭРҮҮЛ МЭНД" АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД  
ХИЙГДЭХ АЖЛЫН ТӨСӨВ

№	Хэрэглэх бараа, материал	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Үнэ	
				Нэг бүр	Нийт
1	Цайны зардал	ширхэг	20	25000	500,000
2	Хөөсөн самбар	ширхэг	1	70000	70,000
3	Баннер	ширхэг	1	250000	250,000
4	Урологийн эмч лекц, үзлэг	хоног	5	200000	1,000,000
5	Эхо	хоног	5	200000	1,000,000
6	Судалгааны оношлуур	ширхэг	500	3,600	1,800,000
	Дархлаа дэмжих багц	ширхэг	500	1400	700,000
7	Тараах материал	ширхэг	400	2000	800,000
	<b>НИЙТ ДҮН</b>				<b>6,120,000</b>